



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

БОЛОВСРОЛЫН СИСТЕМ ДАХЬ АВЛИГА

ДЭЭД БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

ЦУВРАЛ
№3

2017 ОНЫ 11 САР



"Нийтийг хамарсан авлига нийгэмд сая сая долларын хохирол учруулаад зогсохгүй бүх нийтэд чанартай боловсрол олгох үйл хэрэгт хортой нөлөөлдөг. Энэ нь сургуулийн хөрөнгөнөөс хулгайлахаас эхлээд сургалтын стандартыг бууруулж, улмаар боловсролын чанар үр өгөөжийг сулруулж, залуучуудын ирээдүйг бүрхэгдүүлдэг. Иймээс бид түүнийг сайтар хянаж байхгүй бол болохгүй"
Коичиро Матцуура (ЮНЕСКО-ийн ерөнхий захирал, 1999-2009)



ТОВЧ АГУУЛГА

Өнөөдөр хүн төрөлхтний өмнө ажилгүйдэл, чанар муутай боловсрол, авлига зэрэг олон тулгамдсан асуудлууд гарч ирж байна. Түүний дотор авлига дэлхийн дийлэнх улс орнуудын хувьд ихээхэн хурдацтай тархаж байгаа сэтгэл зовоосон асуудлуудын нэг болж байна. Ерээд оны дунд үеэс авлигатай тэмцэх хөдөлгөөн дэлхий дахинаа эхэлж, олон тооны тайлан, олон улсын конвенц, эрх зүйн баримт бичгүүд гарснаас тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенц, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын авлигын эсрэг конвенц, Европын холбооны авлигатай тэмцэх талаар гаргасан тайлан зэргийг дурдаж

болно. Хэдийгээр ийм өргөн хүрээтэй ажиллагаа явуулж ирсэн хэдий ч дорвитой өөрчлөлт гарахгүй байна. Өнгөрсөн хориод жилийн дотор дэлхийн 21 оронд авлигын хэмжээ эрс буурсан байхад 27 оронд байдал улам хүндэрсэн байна. Тэр ч байтугай, авлигын асуудал эдийн засгийн хүрээнээс хальж, нийгмийн бусад салбар руу богино хугацаанд хүчтэй нэвтэрч орсон байна. Нийгмийн хамгийн дээдэлж явах ёстой боловсролын салбар авлига хэмээх энэ хорт хавдарт нэрвэгдэж байгаа тул боловсролын салбарт байгаа авлигын асуудалд энэ дугаараа зориулж байна.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Боловсрол бол хүний үндсэн эрх бөгөөд улс орны хөгжил дэвшлийн хөдөлгөх хүч байдаг. Боловсролын салбарт улсын төсвийн 20-30 хувийг зарцуулдаг учраас авлигад өртөх эрсдэл өндөр байдаг. Боловсролын салбарын авлигын хор уршиг маш их байдаг. Боловсролын салбарт авлига олон янзын хэлбэрээр илэрч байгаа бөгөөд түүний үр уршгаар боловсролын үйлчилгээний чанар доройтож, хүртээмж хомсдож, тэгш байдал алдагдаж, улмаар улс орны хөгжил дэвшилд хортой нөлөө үзүүлж байна. Боловсролын төсвөөс хулгайлсан хөрөнгө нь сургуулийн хүртээмжид сөргөөр нөлөөлж, анги дүүргэлтийг хэтрүүлж, олон ээлжээр хичээллэхэд хүргэдэг. Их дээд сургуулиуд анги танхимаа түрээслэх, сургуулийн мэдлийн газрыг зарах, ажил мэргэжлийн мэдлэг чадвар дорой хүмүүсийг танил тал, улс төрчдийн шахалтаар ажилд авснаар боловсролын стандартын түвшинг доройтуулдаг. Дүн, кредит, диплом цол хэргэмийг худалдаж авах, хууль бусаар олж авах, багш нар тогтсон төлбөрөөс гадна нэмэлт төлбөр төлөхийг оюутнаас шаардах зэрэг нь боловсролын салбарыг доройтуулахад хүргэдэг байна.

Жил бүр Transparency International байгууллагаас авлигын төсөөллийн талаарх статистик мэдээг гаргаж байдаг бөгөөд 2011 онд дэлхийн хүн амын

35 хувь нь өөрсдийн улс орны боловсролын байгууллагууд хэт авлигад автсан гэж үзсэн байна. Үнэндээ боловсролын салбарт оршиж байгаа авлигын талаар хангалттай жишээ баримт байдаг байна. Тухайлбал, хүн амынх нь дөрөвний нэг нь ажилгүй байгаа Серб улсын хувьд 7000 евро буюу дундаж цалингаас 22 дахин их мөнгө төлж байж багшийн ажилд ордог талаар хэвлэл мэдээллээр мэдээлсэн байна. Киргиз улсад сургуульд амжилттай сурахын тулд багшдаа мөнгө төлөх шаардлагатай байдаг ажээ. Дунд сургуулийн нийт сурагчдын 64 хувь нь өөрийн сургуулийн багшаас ганцаарчилсан төлбөртэй нэмэлт хичээл авдаг гэсэн тооцоо гарчээ. 2009 он хүртэл ОХУ-д их сургуулиуд элсэлтийн шалгалтаа өөрсдөө авдаг байжээ. 2004 оны байдлаар элсэлтийн шалгалттай холбогдсон авлига хамгийн өндөр байсан бөгөөд Галицкии, Левин нарын судлаачдын тооцоогоор жилдээ 455 сая орчим доллартай тэнцэхүйц хэмжээнд хүрч байсан гэжээ. Энэтхэг улсын Хүний нөөцийн хөгжлийн яамнаас боловсролын салбар дахь хямралыг судлах тусгай зөвлөлийг байгуулж ажиллуулсны дагуу тус зөвлөлөөс их сургуулийн удирдах ажилтны томилгоонд улс төрийн оролцоо их байгаа учраас их сургуулийн удирдлага нь мэргэжлийн үүднээс бус улс төрийн бодлогын үүднээс аливаа

асуудалд хандах нь газар авсан гэж үзжээ. Дээд боловсролын хэрэгцээ нэмэгдэхийн хирээр улс төрчдийн ивээл дор хувийн сургуулиуд олноор байгуулагдаж Энэтхэгийн их дээд сургуулийн нийт оюутны 60 гаруй хувь нь тэдгээр хувийн сургуулиудад сурдаг бөгөөд хөдөлмөрийн зах зээл дээр гараад ажил хийх чадваргүй хүмүүсийг бэлтгэж байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна. Дэлхийн улс орнуудын авлигын 2016 оны харьцуулсан судалгаагаар Монгол орон 100-аас дөнгөж 38 оноо авч 170 гаруй орноос 87-д бичигдсэн байна. Монгол улсын Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын 2016 оны үнэлгээгээр Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам харьцангуй доогуур үнэлгээ авсан байна. Тухайлбал, авлигын индекс нь 55.5% байхад авлигыг хянах механизм 43%, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 49.2% байна гэсэн үнэлгээ авчээ. Энэ нь боловсролын систем авлигад нэлээд өртсөн байдлыг гэрчилж байна. Саяхан Авлигатай Тэмцэх газраас

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад нийт 14 чиглэл бүхий зөвлөмжийг гардуулж өгсөн байна. Энэхүү зөвлөмжид ерөнхий боловсролын лаборатори сургуулиудын захирлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох, боловсролын байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг батлах, суралцагчдад ногдох хувьсах зардлын хэмжээг үндэслэлтэй, оновчтой болгон тогтоох, хууль бусаар олгогдсон хувьсах зардлыг төсөвт буцаан төвлөрүүлэх арга хэмжээ авах, боловсролын зээлийн сантай байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх, зээлийн сангийн санхүүжилтээр суралцагчдыг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, шинжээчдийн багийн төлөөлөлтэйгээр сонгон шалгаруулж, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, улсын шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тусгажээ.

БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Аливаа улс орнуудын хувьд боловсролын салбар нь улсын төсвийнхөө 20-30 хувийг шингээж байдаг. Гэсэн хэдий ч баян, ядуугаас үл хамааран дийлэнх улс орнуудын боловсролын систем олон тооны бэрхшээл хямралтай тулгарч байна. Тухайлбал төрийн санхүүжилтийн хэмжээ буурч, удирдах дээд шатанд удирдлагын ур чадваргүй хүмүүсээр дүүрч, боловсролын салбараас нийгэмдээ үзүүлж буй үйлчилгээнийх нь чанар суларч, нийгмийнхээ хэрэгцээ шаардлагыг хангахгүй болж байна. Боловсролын салбарын авлига бол шинэ үзэгдэл биш юм. Хэдэн арван жилийн өмнөөс боловсролын системд, тухайлбал, Бразилд багш ажилд авахад, Филиппинд сурах бичиг үйлдвэрлэхэд авлигын зөрчлүүд гарч байжээ.

2014 онд ЮНЕСКО-ийн Боловсролын Төлөвлөлтийн хүрээлэнгээс гаргасан судалгаанд боловсролын салбар авлигад өртөж болох боломжуудыг тодорхойлсон байна. Энд авлигыг залилан, хээл хахууль, луйвар, шахалт, тал тохой татах гэсэн 5 үндсэн төрөлд хувааж авч үзжээ. Залилан бол эрх мэдэлтнүүд боловсролын салбарт зориулсан төсвийн хөрөнгийг улс төрийн сурталчилгаанд ашиглах,


сургуулийн эд хөрөнгийг хувийн сонирхлоор авч хэрэглэх замаар илэрдэг байна. Хууль бусаар өөртөө ашиг олох, төрийн өмчийн эд хэрэгслийг өөрийн болгох зэрэг нь энд багтдаг байна. Элсэлтийн оноо хүрээгүй боловч сургуульд элсэх, мэдлэг чадвар дутмаг боловч ажилд орох, аливаа ажил төрлөө бүтээхийн тулд хээл хахууль өгөх явдал боловсролын салбарт их тохиолддог. Бэлэг сэлт авах, ажил төрөл хурдан бүтээхийн тулд шагнал өгөх, гэрээ хэлцэл хийсний төлөө хувь хүртээх зэргийг хээл хахуульд тооцдог. Луйвар бол эдийн засгийн гэмт хэрэг юм. Боловсролын салбарт хуурамч диплом, гэрчилгээ үйлдэх, худалдаж авах, курс, дипломын ажил, диссертацийг үйлдвэрлэдэг үйлчилгээ хууль бусаар явуулах, интернэтээр гэрийн даалгавар, шалгалтын материал тараах зэргээр луйврын үзэгдэл илэрдэг. Айлган сүрдүүлж, шахалт үзүүлж хөрөнгө мөнгө татах явдал боловсролын салбарт авлигын бусад хэлбэрээс ховор тохиолддог хэдий ч оюутан сурагчдад бэлгийн дарамт үзүүлэх, эцэг эхчүүдээс элдэв шалтгаанаар мөнгө татах, хэрэгцээгүй ном, хэвлэл, бараа материал шахах зэрэг нь элбэг тохиолддог байна. Танил тал, хамаатан садан, нутаг усаа бодож ажилд авах,



**TRANSPARENCY
INTERNATIONAL**
the global coalition against corruption

CORRUPTION PERCEPTIONS INDEX 2016

The perceived levels of public sector corruption in 176 countries/territories around the world.



RANK	COUNTRY/TERRITORY	SCORE
1	Denmark	90
1	New Zealand	90
3	Finland	89
4	Sweden	88
4	Sweden	88
5	Switzerland	86
6	Norway	85
7	Singapore	84
8	Netherlands	83
9	Canada	82
10	Germany	81
10	Luxembourg	81
10	United Kingdom	81
13	Australia	79
14	Iceland	78
15	Belgium	77
15	Hong Kong	77
17	Austria	75
18	United States	74
19	Ireland	73
20	Japan	72

21	Uruguay	71
22	Estonia	70
23	France	69
24	Bahamas	66
24	Chile	66
24	United Arab Emirates	66
27	Bhutan	65
28	Israel	64
29	Poland	62
29	Portugal	62
31	Barbados	61
31	Qatar	61
31	Slovenia	61
31	Taiwan	61
35	Botswana	60
35	Saint Lucia	60
35	Saint Vincent and The Grenadines	60
38	Cape Verde	59
38	Dominica	59
38	Lithuania	59

RANK	COUNTRY/TERRITORY	SCORE
41	Brunei	58
41	Costa Rica	58
41	Spain	58
44	Georgia	57
44	Latvia	57
46	Grenada	56
47	Cyprus	55
47	Czech Republic	55
47	Malta	55
50	Mauritius	54
50	Rwanda	54
52	Korea (South)	53
53	Namibia	52
54	Slovakia	51
55	Croatia	49
55	Malaysia	49
57	Hungary	48
57	Jordan	48
57	Romania	48
60	Cuba	47

60	Italy	47
62	Sao Tome and Principe	46
62	Saudi Arabia	46
64	Montenegro	45
64	Oman	45
64	Senegal	45
64	South Africa	45
64	Suriname	45
69	Greece	44
70	Bahrain	43
70	Ghana	43
72	Burkina Faso	42
72	Serbia	42
72	Solomon Islands	42
75	Bulgaria	41
75	Kuwait	41
75	Tunisia	41
75	Turkey	41
79	Belarus	40
79	Brazil	40

RANK	COUNTRY/TERRITORY	SCORE
79	Chile	40
79	India	40
83	Albania	39
83	Bosnia and Herzegovina	39
83	Jan	39
83	Lesotho	39
87	Moldova	38
87	Paraguay	38
87	Zambia	38
90	Colombia	37
90	Indonesia	37
90	Libya	37
90	Morocco	37
90	The Maldives	37
95	Argentina	36
95	Ber	36
95	El S	36
95	Kos	36
95	Mal	36





бусдаас ялгавартай хандаж дүн тавих зэрэг тал тохой татах явдал боловсролын салбарт ихээхэн тохиолддог гэж энэ судалгаанд дүгнэсэн байна.

Боловсролын салбарын бүх түвшинд авлига гарч болох боломжуудыг ЮНЕСКО-ийн судлаачид тодорхойлж гаргасныг дараах хүснэгтээр харууллаа.

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АВЛИГА ГАРЧ БОЛОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

Чиглэл Санхүү Авлигын илрэл - Дүрэм журам зөрчиж, тогтсон шалгуур, ил тод байдлыг хангаагүй санхүүгийн үйлдэл хийх - Зардлын хэмжээг үндэслэлгүй нэмэгдүүлэх - Залилан хийх, сонирхлын зөрчил үүсгэх	Чиглэл Төрийн сангийн зээл, тусламж Авлигын илрэл - Танил тал, хамаатан саднаа бусдаас дээгүүр үзэж, давуу тал олгох - Хахууль авах - Улс төрийн намын харъяалал, нийгмийн байдал, яс үндсээр нь ялгаварлах - Тогтсон шалгуурыг зөрчсөн үйлдэл хийх	Чиглэл Барилга, засварын ажил тохижуулалт Авлигын илрэл - Тендер шалгаруулалтыг хууль бус явуулах - Бэлтгэн нийлүүлэгчтэй урдчилан тохиролцох - Залилан хийх - Чанаргүй бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх - Мэдээллийг гуйвуулах	Чиглэл Тоног төхөөрөмж, сургалтын материал сурах бичиг, өдрийн хоол зэргийн хуваарилалт Авлигын илрэл - Тендер шалгаруулалтыг хууль бус явуулах - Бэлтгэн нийлүүлэгчтэй урдчилан тохиролцох - Хэрэгцээгүй тоног төхөөрөмж худалдан авах - Мэдээллийг гуйвуулах - Хуурамч нийлүүлэлт хийх
Чиглэл Сурах бичиг бичих Авлигын илрэл - Танил тал харах, хээл хахууль, бэлэг авах замаар сурах бичгийн зохиогчийг сонгох - Зохиогчийн эрхийн эсрэг үйлдэл хийх - Сурах бичиг, сургалтын материалыг оюутан сурагчдад шахах	Чиглэл Багш ажилд томилох, тушаал дэвшүүлэх, зэрэг цол олгох, сургалтанд хамруулах, томилолтоор явуулах Авлигын илрэл - Танил тал харах, хээл хахууль, бэлэг авах замаар багшийн ажилд томилох, тушаал дэвшүүлэх - Улс төрийн намын харъяалал, нийгмийн байдал, яс үндсээр нь ялгаварлах - Хуурамч бичиг баримт ашиглах - Цалин хөлсийг саатуулах, хууль бус суутгал хийх	Чиглэл Мэдээллийн систем Авлигын илрэл - Мэдээллийг зориудаар өөрчлөх - Мэдээллийг нуух - Мэдээллийг зарах - Хууль бусаар мэдээллийг нийтлэх	Чиглэл Магадлан итгэмжлэл Авлигын илрэл Магадлан итгэмжлэлийг хууль бусаар залилж авах (хээл хахууль, бэлэг сэлт өгөх, хуурамч материал бүрдүүлэх, тал тохой татах г.м.)
Чиглэл Багшийн үйл ажиллагаа Авлигын илрэл "Үл үзэгдэх" багш ажиллуулах - Үндэслэлгүйгээр ажил таслах - Хууль бус төлбөр авах (сургуульд элсэх, шалгалт авах, дүн тавих, хувиараа давтлага өгөх) - Улс төр, нийгмийн байдал, яс үндсээр нь ялгаварлах - Бэлгийн дарамт үзүүлэх - Сургуулийн байр, тоног төхөөрөмж ашиглан хувиараа төлбөртэй давтлага өгөх, сургалт явуулах - Хээл хахууль, бэлэг авах		Чиглэл Шалгалт, диплом Авлигын илрэл - Шалгалтын мэдээллийг зарах - Шалгалтанд заль хэрэглэх (хуурах, өөр хүний өмнөөс шалгалт өгөх, бэлэг сэлт өгөх) - Өндөр үнэлгээ авах, анги дэвших, тусгай хөтөлбөрт хамрагдахын тулд хээл хахууль өгөх - Хуурамч диплом, үнэмлэх үйлдвэрлэх - Эрдэм шинжилгээний ажлыг бусдын бүтээлийг хууль бусаар хуулах замаар хийх, эрдмийн зэрэг, цолыг хээл хахуулиар авах	

БАРИМТ 1 - БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ГАРЧ БУЙ АВЛИГЫН ЗАРИМ ЗӨРЧЛҮҮД

Тайланд. Чулалонкор их сургуулийн шалгалтын нэг хуудас материалыг хичээлийн төрлөөс хамаарч 15-30 батаар зардаг нь баригджээ.

Итали. Шалгалтын материалыг урьдчилан олж авахын тулд 1695-3390 доллар төлдөг баримт илэрчээ.

Шотланд. Глазго хотын их сургуульд оюутан, зэрэг горилогчдын бүтээлд бусдын бүтээлээс хуулсан, интернетээс ижил төстэй материалаас авсан, бусад оюутны бүтээлээс хулгайлах явдал байнга гарч байсан учраас компьютерийн программ зохиож, түүнийг илрүүлдэг болсон байна.

Англи. Интернетэд байрлуулсан хуурамч их сургуулиуд 2004 оны үед эрх баригчдаас

тэдгээрийг хаах талаар явуулж байгаа хүч чармайлтаас үл хамааран ихээхэн цэцэглэж байжээ. 1000 фунт стерлингийн төлбөр төлөөд эрдмийн зэрэг олгодог байсан 14 их сургуулийг хаасан байна.

Польш. Тус улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хэлэлцэгдэж байгаа боловсролын салбарт гарч буй авлигын төрлүүдэд “нөхөрсөг харьцаатай” компаниас сургуульд зориулж эд хөрөнгө, материал нийлүүлэх, сургуульд хүүхдээ оруулахын тулд авлига өгөх, сургуулийн эд хөрөнгийг захирал хувьдаа хэрэглэх, дүнгээ засуулахын тулд авлига өгөх, эсвэл төлбөр төлж, тэр багшаасаа нэмэлт давтлага авах зэрэг орж байна.

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АВЛИГАТАЙ ТЭМЦЭЖ БАЙГАА ЗАРИМ АРГА ЗАМ

Мэдээжээр улс орны хэмжээнд авлигатай тэмцэх ажлыг хүчтэй явуулахгүй бол дан ганц боловсролын салбарт авлигатай тэмцээд үр дүнд хүрнэ гэдэг түвэгтэй юм. Гэсэн хэдий ч улс орныхоо нөхцөл байдалд тохирсон бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь тодорхой үр дүнд хүрч, боловсролын салбарыг цэвэршүүлж, эрүүл саруул оюун ухаанаа сорих, уралдуулах орчин болгож чадна. Орчин үеийн хүүхэд залуучуудад ёс суртахууны өндөр мэдлэг чадвар, дадал суулгаж чадваас улс орныхоо ирээдүйн хөгжилд шударга ёсыг дээдлэн бодьтой хувь нэмэр оруулах боломж бий. Авлигатай тэмцэхэд боловсролын салбар онцгой үүрэг гүйцэтгэх ёстой. Юуны өмнө, ёс зүйн хэм хэмжээг хүүхэд залуучуудад багаас нь суулгаж өгөх талаар сургалтын хөтөлбөртөө тусгаж, бүх төрлийн хичээлээр авлигын бүхий л хэлбэртэй тууштай тэмцэх арга замыг зааж сургаж байваас улс орноо авлигын хар нүхнээс татаж гаргана. Энэ талаар гарч байгаа сайн туршлага олон байдаг. Тухайлбал, дэлхийн олон улс оронд багшийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон баримт бичгүүд байдаг. Багшийн ёс зүйн хэм хэмжээний кодекс бол чухал ач холбогдолтой баримт бичиг юм. Гонконгод Авлигатай тэмцэх бие даасан комисс байгуулж,

Боловсролын удирдах газартай хамтран боловсролын байгууллагын ажилтнуудын ёс зүйн кодексийг боловсруулсан байна. Энэ баримт бичигт боловсролын байгууллагын ажилтан хүн ажил олгогч, оюутан сурагч, эцэг эх, хамт ажиллагчид, нийгмийн өмнө ямар үүрэг хүлээж байгааг тодорхой зааж өгсөн байна. Түүнээс гадна, сонирхлын зөрчлийг зохицуулах, боловсролын байгууллагаас гадуур ажил хийх, нууцад хамаарах мэдээлэлтэй харьцаж ажиллах талаар зөвлөмжүүдийг оруулж өгчээ. Нөгөө талаас санхүүгийн чиглэлээр авлигаас урдчилан сэргийлэх талаар боловсролын салбарт нэгдсэн хангалт, нийлүүлэлтийн газар байгуулахаас хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг ил тод болгох зэрэг олон талт арга хэмжээ авч байна. Төрөөс сургуулиудад эд хогшил, бараа материал, үйлчилгээ авах үйл ажиллагааг ил тод болгохын тулд мэдээллийн системийг өргөн хэрэглэх болж байна. Тухайлбал, Мексик улсад “Compranet” хэмээх системийг бараа материал, эд хогшил сургуулиудад нийлүүлэх, төрөл бүрийн үйлчилгээ авахад хэрэглэх болсноор төрөөс хэдий чинээний хөрөнгө ямар зүйлд зарцуулж байгааг харах, ямар компаниуд нийлүүлэлтийн ажилд оролцож байгаа зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод болгосон байна. Сурах бичгийн




тал дээр Норвеги улсад сургалтын материал боловсруулах асуудал эрхэлсэн үндэсний төв байгуулж ажиллуулсан нь үр дүнгээ өгч

байна. Шалгалтыг шударга явуулах, шалгалтын материалыг задруулахгүй байх талаар олон янзын арга хэрэглэж байдгийн заримыг манайд хэрэглэж эхлээд байгаа.

БАРИМТ 2 - ДЭЭД БОЛОВСРОЛЫН СИСТЕМИЙН ХЯНАЛТ –РУМЫН УЛСЫН ТУРШЛАГА

Дээд боловсролын салбарт авлига газар авч байгаа явдалтай тэмцэх зорилгоор төрийн бус байгууллагууд “Цэвэр их сургуулиудын холбоо” байгуулж, дээд боловсролын салбарт шударга ёсыг тогтоох шалгууруудыг тодорхойлох

зорилготой санаачлагыг гаргасан байна. Боловсролын салбар дахь шударга ёс зүйн байдлыг 4 чиглэлээр нийтдээ 100 оноогоор тодорхойлдог байна. Үүнд:



Их сургуулиудын үнэлгээг гадны шинжээчдээс бүрдсэн багаас урдчилсан бэлтгэсэн асуулгыг ашиглан явуулдаг байна. Шинжээчдийн бие даасан байдал, бодтой дүгнэх чадвар, тухайн дээд сургуультай ямар нэг холбоогүй байдалд онцгой анхаардаг байна. 2009-2010 он гэхэд

нийтдээ 42 төрийн өмчийн их сургуулиудыг үнэлсэн байна. Энэ санаачлага нь Румын улсын дээд боловсролын салбарт дорвитой өөрчлөлт хийхэд нөлөөлсөн бөгөөд санал, зөвлөмжүүд нь төрийн бодлогын баримт бичигт орсон байна.

БАРИМТ 3 - COMPOSTELA: АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН ҮҮРЭГ РОЛЬ

Испани улсын Сантьяго де Компостела гэдэг 500 гаруй жилийн түүхтэй их сургуулиас санаачлан их сургуулиудын Compostela холбоог байгуулсанд дэлхийн 70 гаруй их сургуулиуд багтсан байна. Энэ холбооны гол зорилго нь дээд боловсролын тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг явуулж хамтын ажиллагаа өрнүүлэхэд чиглэдэг байна. 2014 оны 9 сард ёс зүй болон авлигатай тэмцэх ажлыг их сургуулиудад өргөн хүрээнд явуулах талаар Познаны тунхаглалыг баталсныг Дэлхийн их сургуулиудын Консорциум болон 700 гаруй их сургуулийн профессор багш нарыг хамарсан Урлагийн болон Шинжлэх ухааны ажилтны дэлхийн академиуд бүрэн дэмжсэн байна. Энэ тунхаглалын гол санаа нь их дээд сургуулиуд хувийн сонирхолдоо хэт автсан хувиа бодсон хүмүүсийг бэлтгэхийн оронд авлигатай тэмцэх, ёс суртахууны хүмүүжлийг төлөвшүүлэхэд чиглэсэн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой. Юуны өмнө, авлигач зан төлөвийн үндэс,

учир шалтгааныг нарийн судалж үзэх хэрэгтэй. Ийм зан төрх байдал нь гол төлөв дээд боловсролтой, удирдах албан тушаалд ажиллаж байгаа хүмүүсийн хүмүүжил, ёс суртахуун, үнэт зүйлийн талаарх мэдлэг чадварын доройтлоос үүдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, төр засаг, удирдах ажилтнуудад нийгмийн зүгээс итгэх итгэл алдарч байгаа энэхүү нөхцөл байдалд их дээд сургуулиуд нийгмийн өөрчлөлтийн хүчтэй хөдөлгүүрийн хувьд чухал үүрэгтэй байдаг. Тухайлбал, их сургуулийн бүхий л сургалтын төлөвлөгөөнд ёс зүй, авлигын эсрэг тэмцэх асуудлыг тусгах, багш нар ёс зүйн хэм хэмжээний талаар хичээл дээрээ байнга заахын зэрэгцээ их сургууль өөрөө сургалт, судалгааны ажил, оюутны мэдлэгийн үнэлгээ, зэрэг цол олгох, албан тушаалд томилох, дэвшүүлэх зэрэг үйл ажиллагаандаа ил тод шударга ёс журмыг нэвтрүүлж үлгэр жишээ үзүүлэх ёстой гэж энэхүү тунхаглалд заажээ.

БОДЛОГЫН ЧАНАРТАЙ ЗӨВЛӨМЖҮҮД

1. НИЙГМИЙН БОДОЛ САНААГ ӨӨРЧЛӨХ ТАЛААР

- a. Авлигыг жинхэнэ нэрээр нь нэрлэж сурах. Боловсролын салбарт гарч байгаа энд дурдсан авлигын хэлбэрүүдийн талаар “буруу үйлдэл” гэх маягтайгаар зөөлрүүлэн тайлбарлах явдал манай нийгэмд түгээмэл байгаа нь авлигатай тэмцэх ажлыг үр дүнд хүргэхгүй байна. Иймээс төрөөс боловсролын салбар дахь авлигатай тэмцэх хөтөлбөрийг гаргаж, бүх нийтээр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлбэл зохино.
- b. Боловсролын салбар дахь авлига бол үр хүүхдэд нь төдийгүй улс орны ирээдүйд хар ул мөртэй, нөхөж баршгүй хохирол учруулахын учир утгыг эцэг эхчүүдэд сайтар ойлгуулах хэрэгтэй. Түүний зэрэгцээ удирдах ажилтнууд, багш сурган хүмүүжүүлэгчид хээл хахууль, бэлэг сэлтээс бүрэн татгалзаж, боловсролын системийг бохир үйлдлээс салгаж, шударга ёс, тэгш эрхийг дээдэлсэн эрдмийн ордон болгохын тулд бүх оюун ухаанаа дайчлан ажиллавал зохино.



2. ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- a. Төсвийн хөрөнгийн хуваарилалт ашиглалтын шинэ шалгуур тогтоож, гадны төсөл тусламжийг ил тод зориулалтын дагуу хэрэгжүүлж, боловсролын төсөв хөрөнгийг жил дараалан өсгөх, улмаар багш нарын цалин хөлсийг байнга дээшлүүлэх урт хугацааны төлөвлөлтийг бий болгож үе шаттай хэрэгжүүлмээр байна.
- b. Боловсролын үйлчилгээний чанарт мониторинг хийх, хяналт тавих механизмыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх хэрэгтэй. Түүний дээр хөндлөнгийн болон олон улсын хяналтын байгууллагуудыг энэ ажилд оролцуулах хэрэгтэй.
- c. Бүх шатны сургуулийн сургалтын үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээний талаар байнга зааж, дэлхийн иргэн болох боловсролыг олгох ажлыг тууштай явуулбал зохино.
- d. Төрийн албаны болон төрийн захиргааны удирдах ажилтан бэлтгэдэг сургалтанд ёс зүйн асуудлыг оруулж, ёс зүйн шалгалтыг төрийн албаны болон төрийн захиргааны ажилтнаас авдаг журмыг бүрэн хэрэгжүүлбэл зохино.
- e. Багшийн ёс зүйн кодексийг боловсруулж мөрдөх хэрэгтэй.
- f. Ард түмний хараа хяналтыг дэмжиж, мэдээлэл өгсөн хүмүүсийг хамгаалах механизмыг бүрдүүлбэл зохино.

3. БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

- a. Боловсролын байгууллагуудын бие даасан байдлыг хангахын зэрэгцээ тэдний өмнө хүрч болохуйц бодьтой зорилт тавьж, багш, оюутан сурагчдын урам зоригийг түүнд төвлөрүүлж, "хуурамч" амжилтаас татгалзах ажлыг газар сайгүй явуулбал зохино.
- b. Бүх шатны боловсролын байгууллагуудыг авлигаас сэргийлэх үүднээс урдчилан сэргийлэх, оношлох зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалтыг явуулж байх хэрэгтэй.
- c. Төрийн үйлчилгээний албаны ялангуяа багш нарын цалин хөлсийг байнга эргэн харж, тэдний нийгмийн халамжийн асуудлыг үе шаттай дэмжиж байх шаардлагатай.
- d. Боловсролын байгууллагуудын бие даасан байдлын талаарх одоо мөрдөж байгаа хууль дүрмийг эргэн харж, тэдний бие даасан байдлыг бүрэн хангахад чиглэсэн бодьтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх цаг болжээ.
- e. Сургалтын төлбөр, сургуулиудаас эцэг эхээс авдаг төлбөрүүдийг бодьтой ил тод болгож, түүнд тогтмол хяналт тавьж байх ёстой.
- f. Эцэг эхийн зөвлөл, багш нарын зөвлөл, их сургуулийн багш нарын холбоо зэргийн үйл ажиллагааг боловсролын байгууллагыг авлигаас ангид байхад чиглүүлж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлдэг болгох хэрэгтэй.

4. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХУВЬД

- a. Эцэг эхчүүд боловсролын байгууллагыг авлигаас салгахад чухал үүрэгтэй учраас үр хүүхэддээ үлгэр жишээ байх, үнэт зүйл, ёс суртахууны талаар сургуулиас өгч байгаа мэдлэг чадварыг цаашид бэхжүүлэх талаар нэмэлт зөвлөлгөө үр хүүхэддээ өгч байвал зохино. Эцэг эхчүүд өөрсдөө авлигаас ангид байж зөв жишээ үзүүлж явах хэрэгтэй.
- b. Сургуулийн эцэг эхчүүдийн зөвлөлийг бэхжүүлж, сургуулийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг болгоход анхаарвал зохино.

5. ОЮУТАН СУРАГЧИЙН ХУВЬД

- a. Оюутан сурагчдыг авлигаас ангид байж, авлигын эсрэг мэтгэлцээн, аян, сурталчилгааны ажилд идэвхитэй оролцуулж байх ёстой. Ялангуяа эцэг эхчүүдээ бэлэг сэлт, хээл хахуульд өртүүлэхгүй байх тал дээр үр хүүхэд нь нөлөөлж чаддаг байхад дэмжлэг үзүүлбэл зохино.

6. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД

- a. Боловсролын салбарт гарч байгаа авлигын шинж тэмдгийг судлан илрүүлж, мэдээлэхэд хэвлэл мэдээллийн болон олон нийтийн санал бодол чухал үүрэгтэй байдаг. Иймээс мэдээллийг ил тод хүртээмжтэй болгох талаарх хууль эрх зүйн зохицуулалт чухал.
- b. Авлигатай тэмцэж байгаа сайн туршлага, шинэ санаа санаачлагыг сурталчлах талаар хэвлэл мэдээллийн байгууллагууд онцгой анхаарвал зохино. Ийм эерэг мэдээлэл нь хүмүүсийн урам зоригийг бадрааж, авлигын талаар өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх, залуучуудын дунд шинэ санаа дэвшүүлэх хөдөлгөөний өрнүүлэх талтай.

ХОЛБОГДОХ ЭХ СУРВАЛЖУУД

Collection of Lifelong Learning Policies and Strategies. UNESCO UIL. <http://uil.unesco.org/lifelong-learning/lifelong-learning-policies-database>

Delors, J. et al. 1996. Learning: the treasure within; report to UNESCO of the International Commission on Education for the 21st Century. Paris, UNESCO.

European Commission. 2000. Memorandum on lifelong learning. [online] Available at: http://arhiv.acs.si/dokumenti/Memorandum_on_Lifelong_Learning.pdf

European Council. 2002. Council resolution on lifelong learning. [online] Available at: <http://eurlex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:C:2002:163:0001:0003:EN:PDF>

European Parliament. 2006. Commission proposal for the introduction of a new action program to promote lifelong learning in the 2007-2013 period. [online] Available at: <http://eur-lex.europa.eu/legalcontent/EN/TXT/?uri=CELEX:32006D1720>

Faure, E. et al. 1972. Learning to Be: the world of education today and tomorrow. Paris, UNESCO.

Field, J. 2006. Lifelong Learning and the New Educational Order. Stoke on Trent, Trentham Books.

Philip H. Coombs. The world crisis in education: A Systemic Analysis. Oxford University Press. 1968

SUMMARY

It is difficult to overstate the significance of lifelong learning in contemporary society. This edition of the policy briefs on Lifelong Learning gives a comprehensive and research-informed introduction to issues in this field.

Governmental, institutional and individual commitments to lifelong learning have brought changes in the meaning and significance of learning across the life course and new teaching and learning practices, as well as significant institutional change. The vision of the learning society and learning cities that is unfolding is highlighted. The policy brief cover the various conceptions of lifelong learning; the factors that impinge on learning through the life course; the social and the economic rationale for lifelong learning; the varied modalities of lifelong learning, from apprenticeship to adult learning, distance education to MOOC etc,. The policy brief provides a set of policy recommendations and policy choice for promoting a lifelong learning. This timely overview will be relevant to policy makers, education and training professionals

in all education sectors, education studies students and the general reader.

The International Center for Higher Education Research of the Mongolian University of Science and Technology presents research-based information in a brief and concise format targeted policy makers and researchers. Readers are encouraged to make reference to the briefs or the underlying research publications in their own publications.

and promotion, critical thinking, innovation and creativity. The policy brief provides a set of policy recommendations and policy choice for creating Research University in Mongolia which targets policy makers, researchers and university leaders.

The International Center for Higher Education Research of the Mongolian University of Science and Technology presents research-based information in a brief and concise format targeted policy makers and researchers. Readers are encouraged to make reference to the briefs or the underlying research publications in their own publications.

ШУТИС-ИЙН ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

Тус төв энэ хичээлийн жилээс сар бүр дээд боловсролын тулгамдсан асуудлаар “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт” цувралыг хэвлэж гарган, мөн ШУТИС-ийн веб хуудсаар түгээх болно. Эдгээр цуврал нь дээд боловсролын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад зориулагдсан бөгөөд энэ цувралын материалыг ашиглах, өөрсдийн судалгаанд ишлэл татан хэрэглэхийг бүрэн дэмжиж, Creative Commons нээлттэй лицензээр зохиогчийн эрхээ баталгаажуулсан.



Судалгааны баг

Доктор, профессор Д.Бадарч

Доктор, профессор Б.Очирбат

Доктор, дэд профессор Т.Намнан

Судлаач Б.Мөнххүж

Хянан тохиолдуулсан: Б.Очирбат